



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 12 сарын 06 өдөр

Дугаар А/813

Булган сум

Гүйцэтгэгчтэй гэрээ шууд байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.4, 60.1.21 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт., Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.2., 34.1.5 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 08 дугаар сарын 04-ний өдрийн XVII хуралдааны Булган аймгийн 2023 оны төсөв баталсан тогтоолд өөрчлөлт оруулах тухай XVII/01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Булган аймгийн Сэлэнгэ, Хутаг-Өндөр суманд механикжсан зоорины ажлын зураг төсөв боловсруулах ажлыг 69,500,000 (жаран есөн сая таван зуун мянга) төгрөгөөр "Өрнөх гүнт" ХХК-тай гэрээ шууд байгуулах эрхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т олгосугай.

2.Гэрээнд заагдсан ажлыг холбогдох хууль, журам, норм дүрмийн дагуу тогтоосон хугацаанд чанартай гүйцэтгэн хүлээлгэн өгөхийг "Өрнөх гүнт" ХХК (Ц.Булганчимэг)-д үүрэг болгосугай.

3.Булган аймгийн Сэлэнгэ, Хутаг-Өндөр суманд механикжсан зоорины ажлын зураг төсөв гүйцэтгэх ажилд чанарын болон хугацааны хяналт тогтмол тавьж хүлээн авахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т даалгасугай.

4.Дээрх ажлын санхүүжилтийг Орон нутгийн хөгжлийн сангийн батлагдсан төсөл арга хэмжээнээс гэрээнд заасан үнийн дүнгээр санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Батцогт)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ